



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 31 өдөр

Дугаар АНЧ8.

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн Онцгой байдлын
хэлтсийн данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1544 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 12,250,000.00 (арван хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй Хьюндай каунти 15-36 УБИ маркийн тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Ц.Цогбадрах)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг актлан сэлбэгийн зориулалтаар нийт 1,945,125.00 (нэг сая есөн зуун дөчин таван мянга нэг зуун хорин тав) төгрөгөөр үнэлэн фондолж ашиглах, илүүдэлтэй болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон зарим сэлбэгүүдийг худалдан борлуулж зохих дансанд орлого болгон авч, тээврийн хэрэгслийн бичиг баримт, улсын дугаарыг бүртгэлээс хасуулахыг тус тус Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Ц.Цогбадрах)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В. Оюумаа В.ОЮУМАА